

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 65.020.40

| | |
|----------------------------------|-----------------|
| Ганц наст цэцэг тарих арга | MNS 6259 : 2011 |
| Method planting of annual plants | |

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2011 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 25 дугаар тогтоолоор батлав.

Энэ стандартыг улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн мөрдөнө.

1 Зорилго

Хот суурин газарт гоёл-чимэглэлийн ганц наст цэцгийг тарьж ургуулахад оршино.

2 Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь гудамж талбай, барилга байгууламжийн орчныг цэцэгжүүлэхэд ганц наст цэцэг тарихад хамаарна.

3 Норматив ишлэл

Энэхүү стандартад дараах баримт бичгийг иш татсан бөгөөд эдгээр стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны материалаас иш татаж хэрэглэнэ.

- ГОСТ 28852:90, Цэцгийн үрслэг. Техникийн шаардлага

4 Нэр томъёо, тодорхойлолт

4.1

Ганц наст цэцэг

Өөрийн бүх амьдралыг зөвхөн нэг жилд багтаан явуулаад хагдардаг ургамал.

4.2

Хоёр наст цэцэг

Амьдралаа хоёр жилийн дотор багтаан гүйцээдэг ургамал. Амьдралын эхний жилд үндэс, навч, ишийг үүсгэн нөөц шим тэжээлийг хуримтлуулан хадгалж өвөлжөөд, хоёрдахь жилдээ цэцэглэж, үр жимс үүсгээд хагдарна.

4.3

Үрслэг

Шилжүүлэн суулгах зорилгоор бойжуулсан залуу ургамал.

5 Тарих арга

5.1 Чимэглэлийн ганц наст цэцгийг үрээр болон үрслэгээр тарина. Ургалтын хугацаа урттай, жижиг үртэй чимэглэлийн ганц наст цэцгийн үрийг 2 дугаар сарын сүүлчээс 3 дугаар сарын 1 дүгээр арав хоногт багтааж, 45см х 35см х 8 см-ийн хэмжээтэй модон хайрцаганд тарина.

5.1.1 Үр тарихад хар шороо элсийг шигшиж 6:4 харьцаатай хольж хэрэглэнэ.

5.1.2 Бэлтгэсэн хөрсийг хайрцганд хийж тэгшлээд, сайтар усална. Ус шингэсний дараа үрээ цацаж, шороо ба элсээр 0,5-аас 1 см зузаантай хучина. Үрийн том, багаас хамаарч тарих гүн харилцан адилгүй байна. Жижиг үрийг 0,1-ээс 0,2 см-т, дунд зэргийн үрийг 0,5 см гүнд тарина.

ТАЙЛБАР 1: Үрийг түргэн соёолуулах, бичил орчин бүрдүүлэх, 90%-иас 95%-ийн чийгтэй байлгах зорилгоор шилээр таглана.



а



б

1-р зураг. Цэцгийн үр тарих

а) шороо хийх

б) шороог тэгшлэх

5.1.3 Үр тарих үеийн тасалгааны дулаан +18°C-ээс + 22°C, хөрс нь + 20°C байна.

5.1.4 Хумсанцэцэг, хумсанбудаг, энхэлгэнэ цэцгийн үрийг ил талбай, цэцгийн мандалд 5-р сарын 25-аас 6-р сарын 5-ны хооронд шууд тарьж болно.

Үрслэг тарих хугацаа

1-р хүснэгт

| д/д | Ургамлын нэр | 1м ² талбайд шилжүүлэх үрслэгийн тоо /ш/ | Тарих хугацаа |
|-----|------------------------------|--|------------------|
| 1 | Antirrhinum-Арслангийн жавьж | 20-30 | 3-р сарын эхээр |
| 2 | Alyssum- Дэмэг цэцэг | 10-15 | 4-р сарын сүүлч |
| 3 | Ageratum-Гүндсамбуу | 15-30 | 3-р сарын сүүлч |
| 4 | Calendula- Хумсанцэцэг | 40-50 | 5-р сарын дунд |
| 5 | Callistephus-Гол гэсэр | 40-50 | 2-р сарын дунд |
| 6 | Celosia-Тахиан залаа | 50-60 | 2-р сарын эхээр |
| 7 | Chrysanthemum- Шиваантиг | 40 | 4-р сарын эхээр |
| 8 | Coreopsis-Мираан | 20-40 | 3-р сарын сүүлч |
| 9 | Cosmos- Энхэлгэнэ | 40-60 | 5-р сарын дунд |
| 10 | Caillardia- Гайларди | 20-25 | 3 сарын сүүлч |
| 11 | Rudbekia-Бүлтэн | 30 | 3-р сарын эхээр |
| 12 | Tagetes-Хилэнцэцэг | 25-30 | 4-р сарын эхээр |
| 13 | Zinnia- Хүмээс | 25-30 | 4-р сарын эхээр |
| 14 | Dahlia-Мандарваа | 5-6 | 3-р сарын дунд |
| 15 | Dimorphoteca-Алталж | 20-25 | 4-р сарын дунд |
| 16 | Centaurea- Хонгорзул | 30-40 | 5-р сарын дунд |
| 17 | Helichrysum- Хуурайцэцэгтэн | 25-30 | 3-р сарын сүүлч |
| 18 | Impatiens- Хумсанбудагцэцэг | 30-35 | 5-р сарын сүүлч |
| 19 | Campanula -Хонхонцэцэг | 20-25 | 2-р сарын эхээр |
| 20 | Dianthus-Башир | 25 | 2-р сарын эхээр |
| 21 | Gypsophila-Тайр | 50 | 5-р сарын сүүлч |
| 22 | Convolvulus-Сэдэргэнэ | 30 | 5-рсарын дундуур |
| 23 | Salvia-хулгана сүүл | 25-30 | 2-р сарын дунд |
| 24 | Clarkia-Цайгана | 20-25 | 3-р сарын эхээр |
| 25 | Scabiosa- Бааварцэцэг | 35-40 | 4-р сарын эхээр |
| 26 | Eschscholzia-Намуулиг | 25-30 | 3-р сарын дунд |
| 27 | Phlox-Аранзалаа | 20-30 | 2-р сарын эхээр |
| 28 | Portulaca-Мориншүд | 25-30 | 3-р сарын эхээр |
| 29 | Petunia-Хунцэцэг | 15-20 | 3-р сарын эхээр |
| 30 | Tropaeolum-Гялбалзал | 20-25 | 5-р сарын дунд |
| 31 | Verbena-Ташуур өвс | 30-40 | 3-р сарын эхээр |
| 32 | Viola-Нил /алаг нүдэн/ | 15-20 | 3-р сарын эхээр |

ТАЙЛБАР 1: Эхээр- тухайн сарын эхний арав хоногт, Дунд- тухайн сарын хоёрдугаар арав хоногт, Сүүлч- тухайн сарын гуравдугаар арав хоногт

5.2 Үрслэг шилжүүлэн суулгах

Үр соёолсноос хойш 2-оос 4 навчтай болсон үед 5см х 5см, 7см х 7см зайтайгаар шилжүүлэн суулгана /2-р зураг /.



а

б

в

2-р зураг. Үрслэг шилжүүлэх байдал

- а) үрслэг 2-оос 4 навчтай болсон үе, б) 5смх5 см зайтайгаар шилжүүлэх
в) 7смх7см зайтайгаар шилжүүлэн суулгах

5.2.1 Үрслэгийг шилжүүлэн суулгаснаас хойш тасалгааны дулааныг + 3⁰С-аас + 5⁰С-аар бууруулах буюу +15⁰С-аас+ 18⁰С-тай, гэрэл сайтай газар тавьж, усалгааг өдөрт 1 удаа, хөрс сийрүүлэх ажлыг 7 хоногт 1 удаа тогтмол хийнэ.

5.3 Үрслэгийг гаднах нөхцөлд дасгах

5.3.1 Үрслэгийг талбайд шууд тарихад амьдралт муу байдаг учраас 4-р сарын сүүлч, 5-р сарын эхээр гадны нөхцөлд аажмаар дасгана.

5.3.2 Хайрцагтай үрслэгийг нартай, дулаан, салхигүй өдөр зөөж дарлаганд гарган, шилэн буюу нийлэг хальсан жаазаар таглана.

5.3.3 Салхитай хүйтэн өдөр шилэн жаазын дээрээс бүтээлгээр хучиж өгнө. 5-р сарын эхний 15 хоногоос өглөө жаазыг сөхөж, орой таглаж, 5-р сарын сүүлчээс агаарын дулаан +10⁰С-ээс дээш тогтворжсон үед жаазыг бүрэн авч, орой таглана.

5.3.4 Өрөө тасалгаанд үрслэг ургуулж байгаа нөхцөлд өдөртөө таганд гаргаж, оройд оруулна.

5.3.5 Үрслэг мөчирлөлт сайтай, богино иштэй байвал тээвэрлэлт, савлалт, шилжүүлэн суулгалтыг сайн даана.

5.4 Задгай талбайд үрслэг шилжүүлэн суулгах

5.4.1 Сайн чанарын шилбэ бүдүүнтэй үрслэгийг ил хөрс, мандалд суулгана.

5.4.2 Үрслэг суулгах ил талбайн хөрсийг 20-оос 25 см гүн хагалж, чулуу, хог ургамлын үндсийг нь түүж цэвэрлээд, багсармал бордоог хольж чийглэн, тэгшилсэн байна.

5.4.3. Үрслэгийг задгай талбайд цочир хүйтрэлт өнгөрсний дараа 6-р сарын 2-р 10 хоногоос эхлэн шилжүүлэн суулгана.

5.4.4 Цэцгийн мандалд суулгах үрслэгийг нэг өдрийн өмнө усална. Хайрцагнаас үрслэгээ авахдаа үндэс гэмтэхээс сэргийлж, шорооны хамт зүсэж авна.

5.4.5 Үрслэгийг 15-аас 20 см зайтай буюу 1 м² талбайд 50-иас 70 ширхэг байхаар суулгана.

5.4.6 Үрслэгийг суулгахдаа анхны навч хүртэл хөрсөнд булж өгнө.

5.4.7 Үрслэгийг бүрхэг өдөр ба орой суулгана.

5.4.8 Үрслэгийг ил талбай, мандалд суулгаад дараа нь шууд усална.

5.4.9 Үрслэгийг суулгаснаас хойш үзлэг хийж, 3-аас 5 хоногт багтаан нөхөн тарилтыг хийнэ.

6 Тарьсан ургамлыг арчлах

6.1 Хөрсийг нягтрахаас сэргийлж 7 хоногт 1 удаа сийрүүлж, хог ургамлыг түүнэ.

6.2 Усалгааг үрслэг суулгасны дараа эхний 7 хоногт өдөрт 2 удаа, цаашид өдөрт 1 удаа өглөө, оройн цагаар хийнэ.

6.3 Тарьсан ургамлын өсөлт хөгжилтийг сайжруулж, бутлалтыг нэмэгдүүлэх зорилгоор 10 л усанд 5-аас 7 г калийн давс, 15-аас 20 г суперфосфат хийж 5-аас 6 м² талбайг бордоно.

7 Үрслэгийг тээвэрлэх, савлах

7.1 Үрслэгийг ургаж буй хайрцагтай нь тээвэрлэнэ.

7.2 Үрслэгийг өөр саванд савлах шаардлагатай бол сайтар услаад үндэсний шороотой авч, савлах хайрцагандаа чигжүү өрж тавина.

7.3 Тээвэрлэсэн үрслэгийг бэлдсэн талбай, мандалд тухайн өдөртөө багтааж суулгана.

ТӨГСӨВ.